



# ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ-ЫН (EJU) ГАРЫН АВЛАГА

~ Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг шалгуур болгон  
Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөл ~



JASSO

БИЕ ДААСАН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУУЛИЙН ЭТГЭЭД  
**ЯПОНЫ ОЮУТНЫГ ДЭМЖИХ БАЙГУУЛЛАГА**  
Japan Student Services Organization

## ГАРЧИГ

Өмнөх үг . . . . .	03
Гадаад оюутан элсүүлэх сонгон шалгаруулалтын тухай . . . . .	04
Японд суралцах шалгалт (EJU) . . . . .	05
Японд суралцах шалгалт (EJU)-ын бэлтгэл . . . . .	09
Японд суралцах хүртлэх алхамууд . . . . .	11
“Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөл”-ийн талаар . . . . .	14
Тэтгэлэг (Боловсрол Шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэгийн хүсэлт гаргах тогтолцооны тухай . . . . .	17

**Японд суралцах шалгалт  
(EJU)-ын веб сайт:  
[www.jasso.go.jp/eju/](http://www.jasso.go.jp/eju/)**



## ӨМНӨХ ҮГ

Энэхүү гарын авлагад “Японд суралцах шалгалт (EJU)” болон “Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөл”-ийн талаар танилцуулна.

Японд суралцах шалгалт (EJU) гэдэг нь хувийн зардлаар Япон улсын их, дээд сургууль (факультет)-д элсэн суралцах хүсэлтэй гадаад иргэдэд зориулан Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO) зохион байгуулдаг шалгалт юм.


Японд очихгүйгээр өөрийн эх орондоо буюу 14 улс, бүс нутгийн 17 хотод (2015 оны 3-р сарын байдлаар) элсэлтийн шалгалт өгөх боломжтой.

Японд суралцах шалгалт (EJU)-аар япон хэлний мэдлэг болон үндсэн мэдлэгийг шалгах бөгөөд гадаад оюутныг хүлээн авч суралцуулдаг олонх их, дээд сургууль тус шалгалтын дүнг гадаад оюутан элсүүлэх шалгуур үзүүлэлтдээ шаарддаг.

Элсэлтийн шалгалтандаа Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг харгалзан үздэг сургуулиудын нэрсийн жагсаалт:  
[http://www.jasso.go.jp/ryugaku/study\\_j/eju/examinee/us](http://www.jasso.go.jp/ryugaku/study_j/eju/examinee/us)

Түүнчлэн Япон улс руу явалгүйгээр өөрийн эх орондоо Японд суралцах шалгалт (EJU) өгөн Японы их дээд сургуульд элсэн орох зөвшөөрөл авах тогтолцоо байдаг ба үүнийг “Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” гэнэ. Энэхүү зөвшөөрлийг олгодог 140 гаруй сургууль байдаг.

(Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг харгалзан үзээд “Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөл” олгодог их, дээд сургуулиудын нэрсийн жагсаалт:  
<http://www.jasso.go.jp/eju/baij.html>)



## ГАДААД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТУХАЙ

Япон улсын их, дээд сургуулиуд дотор гадаад оюутанд зориулсан тусгай элсэлтийн сонгон шалгаруулалт зохион байгуулдаг сургууль цөөнгүй байдаг. Элсэлтийн сонгон шалгаруулалтад дараах материал, шалгалтын дүн зэргүүдийг бүрдүүлэхийг шаарддаг.

- ① Өргөдөл материалаар сонгон шалгаруулах
- ② Мэдлэгийн шалгалт
- ③ Ярилцлагын шалгалт
- ④ Богино эссе, зохион бичлэг
- ⑤ Бусад ур чадвар, мэргэжлийн тусгай шалгалт
- ⑥ Японд суралцах шалгалт (EJU)
- ⑦ Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт
- ⑧ Их, дээд сургуульд элсэх “Элсэлтийн ерөнхий шалгалт”

Энэхүү гарын авлагад “Японд суралцах шалгалт (EJU)”-ын тухай танилцуулна.

# ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)

(2015 оны 8-р сарын байдлаар)

Японд суралцах шалгалт (EJU) нь Япон улсын их, дээд сургууль (факультет)-д элсэн суралцах хүсэлтэй хүмүүсийн япон хэлний мэдлэг болон үндсэн мэдлэгийг шалгах шалгалт юм.


## 1. ШАЛГАЛТ АВАХ ГАЗАР

Японд: 16 хот

Гадаадад: 14 улс, бүс нутгийн 17 хот

Японд болон гадаад улсад ч шалгалт өгөх боломжтой!

Энэтхэг, Индонези, Солонгос, Сингапур, Шри-Ланка, Тайланд, Тайвань, Филиппин, Вьетнам, Хонгконг, Малайз, Мианмар, Монгол, Орос.



Японд суралцах шалгалтын талаар гадаад улс оронд лавлагаа авахад:

<http://www.jasso.go.jp/eju/contact.html>

## 2. ШАЛГАЛТ АВАХ ХУГАЦАА

Жил бүрийн 6-р сард (1 дэх), 11-р сард (2 дахь)

## 3. ШАЛГАЛТЫН БҮРТГЭЛЭЭС ШАЛГАЛТЫН ДҮНГ МЭДЭГДЭХ ХҮРТЭЛ

		1 дэх	2 дахь	
1	Шалгалтанд бүртгүүлэх өргөдөл гаргах	2-р сар~ 3-р сар	7-р сар	Шалгалт өгөгч "Японд суралцах шалгалт (EJU) өгөх заавар"-ыг аван, шалгалтын төлбөрийг төлөн өргөдөл гаргана. ※ Шалгалтын бүртгэл явагдах хугацаа жил бүр өөр байдаг тул заавал шалгана уу.
2	Шалгалт өгөх эрхийн бичиг хүлээн авах	5-р сар	10-р сар	Шалгалт өгөх эрхийн бичгийг бүртгүүлсэн хүн рүү шуудангаар илгээнэ. ※ Монголд бүртгүүлсэн тохиолдолд шалгалт өгөх эрхийн бичгийг бүртгэл хийх үед шалгалт өгөгчид өгнө.
3	Шалгалт авах өдөр	36-р сар	11-р сар	Шалгалт өгнө.
4	Шалгалтын дүнг мэдэгдэх хуудас хүлээн авах	7-р сар	12-р сар	Шалгалтын дүнг мэдэгдэх хуудсыг шалгалт өгөгч рүү шуудангаар илгээнэ. ※ Монголд шалгалт өгсөн тохиолдолд хариу ирснийг шалгалт өгөгч рүү утасдаж мэдэгдэнэ. Шалгалт өгөгч өргөдөл гаргах үедээ мэдүүлсний дагуу JASSO шалгалт өгөгчийн дүнг элсэхийг хүссэн сургууль руу нь илгээнэ.

## 4. ШАЛГАЛТ АВАХ ХИЧЭЭЛҮҮД БОЛОН ШАЛГАЛТ АВАХ ХЭЛ

Шалгалт өгөгч нь дараах хичээлүүдээс өөрийн элсэхийг хүссэн сургуулийнхаа заасан 1-3 хичээлийг сонгож шалгалт өгнө. Байгалийн ухаан, нийгмийн ухааны хичээлийг хоёуланг нь зэрэг сонгох боломжгүй.

Үндсэн мэдлэгийг шалгах хичээлүүд (Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Математик)-ийн шалгалтыг япон хэл, англи хэлний аль нэгээр өгнө (Япон хэлний шалгалтыг зөвхөн япон хэлээр өгнө.). Шалгалт өгөгч нь өөрийн элсэхийг хүссэн сургуулийн элсэлтийн шалгуурт тохируулан, шалгалтанд бүртгүүлэх өргөдлийн маягт бөглөж өгөхдөө дээрхийн аль нэг хэлийг сонгоно.

Шалгалт авах хичээлүүд	Зорилго	Үргэлжлэх хугацаа	Оноо	Хичээл сонгох	Шалгалт авах хэл	
Япон хэл	Японы их, дээд сургуулиудад суралцахад шаардлагатай япон хэл (Академик япон хэл)-ийг шалгах	125 мин	Уншлага, сонсгол-уншлага 0-400 оноо Бичгийн шалгалт 0-50 оноо	/	Зөвхөн япон хэлээр	
Үндсэн мэдлэгийг шалгах	Байгалийн ухаан	Японы их, дээд сургуулиудад техникийн чиглэлээр суралцахад шаардагдах байгалийн ухааны мэдлэгийг шалгах	80 мин		0-200 оноо	Физик, хими, биологийн хичээлээс 2 хичээлийг сонгоно
	Нийгмийн ухаан	Японы их, дээд сургуулиудад суралцахад шаардагдах нийгмийн ухааны үндсэн мэдлэг, тэр дундаа сэтгэн бодох чадвар, учир зүйг олох чадварыг шалгана.	80 мин	0-200 оноо	/	Япон хэл, англи хэлний аль нэгийг сонгоно
	Математик	Японы их, дээд сургуулиудад суралцахад шаардагдах математикийн үндсэн мэдлэгийг шалгана.	80 мин	0-200 оноо		

### [Нэмэлт тайлбар]

- **Япон хэлний шалгалтын дараалал, үргэлжлэх хугацаа:** Бичгийн шалгалт (30 мин) → Уншиж ойлгох (40 мин) → сонсож уншиж ойлгох → сонсох (сонсож уншиж ойлгох болон сонсож ойлгох нийт 55 мин)
- **Байгалийн ухааны шалгалтын бүтэц:** Шалгалт өгөгч физик, хими, биологи гэсэн 3 хичээлээс өөрийн элсэн орохыг хүссэн сургуулийн элсэлтийн шалгуурт тохируулан 2 хичээлийг шалгалт өгөх үед сонгоно. (Хичээл тус бүр 100 оноо)
- **Нийгмийн ухааны шалгалт:** Нийгмийн ухааны шалгалт нь Японд суралцах шалгалт (EJU)-ын нэгэн өвөрмөц хэсэг юм. Япон улсын ахлах сургуулийн хичээлүүд болох “нийгэм” (улс төр, эдийн засаг), “газарзүй”, “түүх”-ийн хичээлүүдийн нэгдсэн шалгалт юм.
- **Математикийн шалгалтын бүтэц:**  
**Курс 1:** Хүмүүнлэгийн ухааны сургууль болон математикийн мэдлэг шаардах нь харьцангуй бага байгалийн ухааны салбарын сургуулиудад элсэхэд хэрэгтэй.  
**Курс 2:** Харьцангуй математикийн мэдлэг их шаарддаг сургуулиудад элсэхэд хэрэгтэй.  
 Шалгалт өгөгч нь өөрийн элсэхийг хүссэн сургуулийн элсэлтийн шалгуурт тохируулан дээрх 2 курсаас аль нэгийг шалгалт өгөх үед сонгоно.

## 5. ХАРИУЛАХ АРГА

Япон хэлний шалгалт хариулт дугуйг харлуулах болон бичгийн шалгалт гэсэн хоёр аргаар хариулна.

Байгалийн ухаан, нийгмийн ухаан, математикийн шалгалт хариулт дугуйг харлуулна.

## 6. ШАЛГАЛТЫН АГУУЛГА

Дараах веб сайтаас шалгалтын агуулгыг харж болно. Үндсэн мэдлэг шалгах хичээлийн (байгалийн ухаан, нийгмийн ухаан, математик) шалгалт японы ахлах сургуулийн сургалтын агуулгын хүрээнд байна.

<http://www.jasso.go.jp/eju/syllabus.html>

## 7. ШАЛГАЛТ ӨГӨГЧДӨД ТАВИХ ШААРДЛАГА, ШАЛГАЛТ ӨГӨХ БОЛОМЖ

Японд суралцах шалгалт (EJU) өгөхөд ямар нэгэн болзол, шалгуур заадаггүй. Насны хязгаар ч байдаггүй. Ямар ч хүн хэдэн ч удаа өгөх боломжтой.

## 8. ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-ЫН ДҮНГ ШАЛГУУР БОЛГОДОГ СУРГУУЛИУД

Японы 700 гаруй их, дээд сургууль (бараг бүх улсын сургууль) элсэлтийн шалгууртаа японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг шаарддаг.

Элсэлтийн шалгалтандаа Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг харгалзан үздэг сургуулиудын нэрсийн жагсаалт:  
<http://www.jasso.go.jp/eju/use.html> )

## 9. ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТЫН ДҮНГИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Японд суралцах шалгалт (EJU)-ын сүүлийн 4 удаа (2 жил)-гийн дүн хүчинтэй байдаг. Мөн элсэхийг хүссэн сургуульдаа эдгээр шалгалтуудын зөвхөн нэгнийх нь дүнг л мэдүүлэх боломжтой. Жишээлбэл: А их сургууль 2015 оны 1 дэх удаагийн шалгалт (6-р сар), 2 дахь удаагийн шалгалт (11-р сар), 2014 оны 2 дахь удаагийн шалгалт (11-р сар) гэсэн 3 удаагийн шалгалтын дүнг хэрэглэх бол шалгалт өгөгч нь өөрийн өгсөн эдгээр 3 шалгалтаас хамгийн сайн гэж бодсон дүнгээ өөрөө сонгон, тухайн шалгалтын бүртгэлийн дугаарыг А их сургуульд мэдүүлнэ.

- Зарим сургууль сүүлийн 4 удаагийн шалгалтын дүнг мэдүүлэхийг зөвшөөрөх тохиолдол байхад, тухайн жилийн зөвхөн 1 дэх удаагийн шалгалт, эсвэл зөвхөн 2 дахь удаагийн шалгалтын дүнг мэдүүлэхийг шаарддаг тохиолдол ч байдаг. Сургууль бүр өөр өөр байдаг учраас элсэхийг хүссэн сургуулийнхаа оюутан элсүүлэх заавраас сайтар харж нягтална уу.
- 1 дэх удаагийн шалгалт (6-р сар)-ын япон хэлний шалгалтын дүн, 2 дахь удаагийн шалгалт (11-р сар)-ын нийгмийн ухааны хичээлийн шалгалтын дүн гэх мэтээр өөр өөр удаагийн шалгалтын дүнг тус тусад нь мэдүүлэх боломжгүй.

## 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ

Бие эрхтэний хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, том хэмжээтэй асуултын хуудас ашиглан шалгалт өгөх, шалгалтын цагийг сунгах гэх мэт тусгай дэмжлэг авах шаардлагатай тохиолдолд өргөдлийн маягт өгөхөөсөө өмнө шалгалт зохион байгуулагч байгууллагад хандана уу.

- Шалгалт өгөх үед авах тусгай дэмжлэг, сургуульд элсэн орсны дараа шаардагдах тусламж, дэмжлэгийн талаар дараах байгууллагатай зөвлөлдөнө үү.

DO-IT Japan office

<http://doit-japan.org/accommodation/inquiry/>



# ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТЫН БЭЛТГЭЛИЙН ТАЛААР ИХ ГАРДАГ АСУУЛТ

АСУУЛТ  
1

Японд суралцах шалгалт (EJU)-ын урьд жилүүдийн асуултуудыг хаанаас харж болох вэ?

ХАРИУЛТ  
1

Урьд жилүүдэд явагдсан шалгалтын асуултуудын эмхтгэл ном Японы томоохон номын дэлгүүрүүдийн япон хэлний тасгуудад борлуулагддаг. Мөн шалгалт зохион байгуулахад хамтран ажилладаг байгууллага болон японы оюутныг дэмжих байгууллага (JASSO)-ын хилийн чанад дахь оффис зэрэг газруудаас лавлаж болно. (Индонези, Солонгос, Тайланд, Малайзад байна. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.jasso.go.jp/about/jeic.html](http://www.jasso.go.jp/about/jeic.html) вэб сайтаас харна уу.)

Японд суралцах шалгалт (EJU)-ын өмнөх жилүүдийн асуултууд Сонсож ойлгох-сонсож уншиж ойлгох шалгалтын асуултууд, CD-тэй



Японд суралцах шалгалт (EJU)-ын асуултууд  
[http://www.jasso.go.jp/ryugaku/study\\_j/eju/examinee/publish/](http://www.jasso.go.jp/ryugaku/study_j/eju/examinee/publish/)

Өмнөх жилүүдэд явагдсан шалгалтын асуултуудыг дараах веб сайтаас харж боломжтой.

Японд суралцах шалгалт (EJU)-ын асуултууд болон зөв хариултууд  
[http://www.jasso.go.jp/ryugaku/study\\_j/eju/examinee/pastpaper\\_sample.html](http://www.jasso.go.jp/ryugaku/study_j/eju/examinee/pastpaper_sample.html)

АСУУЛТ  
2

*Нийгмийн ухааны шалгалтанд хэрхэн бэлдэх вэ?*

ХАРИУЛТ  
2

Нийгмийн ухааны шалгалтанд нийгэм, газарзүй, түүхийн чиглэлийн хичээлүүдээс ерөнхий асуулт ирдэг. Хичээл тус бүрийн үндсэн мэдлэгийг шалгахаас гадна, өгөгдсөн асуудал, график зэргийг уншиж ойлгох, сэтгэн бодох чадварыг шалгадаг шалгалт юм. Шалгалтын агуулга болон веб сайтад тавигдсан байгаа өмнөх жилүүдийн шалгалтын асуултуудыг хараарай. Мөн гол төлөв нийгмийн салбарын асуултууд байдаг тул японы ахлах сургуулийн сурагчдад зориулсан улс төр, эдийн засаг, өнөөгийн нийгмийн сурах бичгүүдээс газарзүй А, дэлхийн түүх А, японы түүх А зэргийн үндсэн сэдвүүдийг сайтар давтаарай.

# ЯПОНД СУРАЛЦАХ ХҮРТЛЭХ АЛХАМУУД

## Алхам 1 ЯПОНД СУРАЛЦАХ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

- ◆ Веб сайтаас мэдээлэл цуглуулах

### **JASSO** веб сайт

- <http://www.jasso.go.jp/ryugaku/>

Японд суралцах портал сайт-Gateway to Study in Japan

- <http://www.g-studyinjapan.jasso.go.jp/>

Тэтгэлэгийн мэдээлэл, сургуулиудын мэдээлэл, японд суралцах гадаад оюутны шалгалтын мэдээлэл, япон улсад амьдрах талаарх мэдээлэл, японд суралцах мэдээллийн өдөрлөг, японд суралцах шалгалт (EJU).

“STUDY IN JAPAN” Японд суралцах талаар ерөнхий заавар

- <http://www.g-studyinjapan.go.jp/jp/index.html>

(Япон, Англи, Солонгос, Хятад, Тайланд, Индонези, Вьетнам, Франц, Испани, Орос, Араб хэлээр үзэх боломжтой)

Японы засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээлэл, японд суралцаад эх орондоо буцсан гадаад оюутнуудын холбоо, японд сурсан туршлагатай хүмүүсийн үг, захиас гэх мэт.

### **JAPAN STUDY SUPPORT**

- <http://www.jpss.jp/>

(Япон, Англи, Солонгос, Хятад, Тайланд, Индонези, Вьетнам хэлээр үзэх боломжтой.)

Сургууль хайх, оюутны тэтгэлэг хайх, элсэлтийн шалгалтын мэдээлэл

- ◆ Японд суралцах мэдээллийн өдөрлөг, танилцуулга, семинар зэрэгт оролцох

- [http://www.jasso.go.jp/study\\_j/event.html](http://www.jasso.go.jp/study_j/event.html)

## Алхам 2 СУРГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

Элсэхийг хүссэн сургуулийнхаа веб сайт болон оюутан элсүүлэх зарлалаас “хувийн зардлаар суралцах гадаад оюутан элсүүлэх заавар”-ын талаарх мэдээлэл олж авах.

- ☑ Сургуулийн веб сайтаас сургуулийн танилцуулга, элсэлтийн заавар зэргийг татаж авах боломжтой.



### **Алхам 3 ЭЛСЭХИЙГ ХҮССЭН СУРГУУЛИЙНХАА ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН НӨХЦЛҮҮД, ШАЛГАЛТЫН АРГАЧЛАЛ, ШАЛГАЛТ БОЛОХ ӨДӨР ЗЭРГИЙГ НЯГТАЛЖ ШАЛГАХ.**

Эн тэргүүнд элсэхийг хүссэн сургуулийнхаа элсэлтийн зааварчилгаа, өргөдлийн маягт зэрэгтэй танилцаад элсэлтийн шалгалтын нөхцлүүдийг нягталж шалгана. Тухайн сургуулийн элсэлтийн сонгон шалгаруулалтад Японд суралцах шалгалт (EJU)-ын дүн хэрэгтэй эсэхийг нягтална. Хэрэгтэй тохиолдолд тухайн сургууль Японд суралцах шалгалт (EJU)-ыг ямар хичээлээр, ямар хэлээр, хэд дэх удаагийн шалгалтыг өгсөн байх шаардлагатай зэргийг нягталж шалгана.

(Сургуулийн элсэлтийн зааварчилгааны жишээ:)

Японд суралцах шалгалтын япон хэл, нийгмийн ухаан, математик (курс 1)-ийн шалгалтуудыг өгсөн байх.

Нийгмийн ухаан, математик (курс 1)-ийн шалгалтуудыг япон хэлээр өгсөн байх.

Хэйсэйгийн 27-р (2016) оны 11-р сард зохион байгуулагдах 2 дахь удаагийн Японд суралцах шалгалтыг өгсөн байх.

### **Алхам 4 ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-Д БҮРТГҮҮЛЭХ**

“Японд суралцах шалгалт (EJU)-ыг хилийн чанадад зохион байгуулагч байгууллага ([www.jasso.go.jp/eju/contact.html](http://www.jasso.go.jp/eju/contact.html))-аас шалгалтад бүртгүүлэх өргөдлийн маягтыг авна.

☑ Японд суралцах шалгалт (EJU)-д бүртгүүлээд мартаж, элсэхийг хүссэн сургуулийнхаа заасан хичээлээс өөр хичээлийн шалгалтыг андуурч өгөх гэх мэт тохиолдлуудад тухайн сургуульдаа элсэн орох боломжгүй болохыг анхаарна уу.

Шалгалтанд бүртгүүлэхэд “шалгалт өгөх эрхийн бичиг” олгоно. Энэхүү “шалгалт өгөх эрхийн бичиг” нь мэдээж шалгалт өгөхөд хэрэгтэй. Мөн их, дээд сургуульд өргөдөл гаргах үед шаардах тохиолдол байдаг тул шалгалт өгснийхөө дараа ч хаяж, гэж болохгүйг анхаарна уу.

※ Японд суралцах шалгалт (EJU)-д бүртгүүлснээр японы их, дээд сургуулиудад бүртгүүлсэн гэсэн үг биш гэдгийг анхаарна уу.

## Алхам 5 ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ ӨГӨХ

Шалгалтын өмнө, шалгалтын гарын авлагад бичигдсэн анхаарах зүйлсийг сайтар уншина уу.

## Алхам 6 ЭЛСЭН СУРАЛЦАХЫГ ХҮССЭН СУРГУУЛЬДАА ӨРГӨДӨЛ ГАРГАХ

- ✓ Японд суралцах өргөдөл гаргахдаа элсэхийг хүссэн сургуулийнхаа өргөдлийн маягтад шалгалтын бүртгэлийн дугаарыг бичин, шалгалт өгөх эрхийн бичиг мөн дүнгийн тодорхойлолтын хуулбарыг явуулах шаардлагатай.
- ✓ Их, дээд сургуулиуд Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг японы оюутныг дэмжих байгууллагаас шууд лавлах боломжтой байдаг.

## Алхам 7 ЭЛСЭЛТИЙН БИЧИГ БАРИМТУУДЫГ БҮРДҮҮЛЭХ

Тэнцсэн тохиолдолд элсэлтийн бичиг баримтуудыг бүрдүүлж эхэлнэ.

### “Student Guide to Japan”

Японд суралцахыг хүссэн хүн бүрт зориулсан японд суралцах үндсэн мэдээллүүдийг нэг дороос үзэж болох ном, товхимолууд

[http://www.jasso.go.jp/study\\_j/sgtj.html](http://www.jasso.go.jp/study_j/sgtj.html)



## ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-ЫН ДҮНГ ШАЛГУУР БОЛГОН ЯПОНД ОЧИХООС ӨМНӨ АВАХ ЭЛСЭЛТИЙН ЗӨВШӨӨРӨЛ

### “ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-ЫН ДҮНГ ШАЛГУУР БОЛГОН ЯПОНД ОЧИХООС ӨМНӨ АВАХ ЭЛСЭЛТИЙН ЗӨВШӨӨРӨЛ” ГЭЖ ЮУ ВЭ?

Японы их, дээд сургуулиуд дунд Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг шалгуур болгон Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөл олгодог сургууль байдаг. Тус зөвшөөрлөөр дараах аргаар элсэх боломжтой.

- Өөрийн эх орондоо Японд суралцах шалгалт (EJU) өгөн, Японы их, дээд сургуульд шууд элсэх өргөдөл илгээнэ.
- Японд суралцах шалгалт (EJU)-ын дүн, ахлах сургуулийн дүн зэргийг шалгуур болгон, өргөдөл болон илгээсэн бичиг баримтаар сонгон шалгаруулж шалгалтанд тэнцсэн эсэхийг шийдвэрлэдэг.  
(Зарим сургууль тухайн улсад нь ярилцлагын шалгалт болон бичгийн шалгалт зохион байгуулах нь ч бий.)
- Шалгалт өгөхөөр Япон улсад очих шаардлага байхгүй.



## ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-ЫН ДҮНГ ШАЛГУУР БОЛГОН ЯПОНД ОЧИХООС ӨМНӨ АВАХ ЭЛСЭЛТИЙН ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОДОГ СУРГУУЛИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг шалгуур болгон Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрлийг олгодог их, дээд сургуулиудын мэдээлэл (Сургуулийн нэр, факультет, тэнхимийн нэр, Японд суралцах шалгалт (EJU)-ын өгөх хичээлийн нэр, шаардлагатай бичиг баримт гэх мэт)-ийг дараах веб сайтаас харна уу.

<http://www.jasso.go.jp/eju/baij.html>



Японд суралцах шалгалт (EJU) явагдах өдөр шалгалтын байрнаас Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрлийг олгодог их, дээд сургуулиудын мэдээлэл танилцуулга, зарим сургуулийн танилцуулга



зэргийг авч болно.

Японд суралцах талаар зөвлөгөө зохион байгуулж буй өдөрлөг, танилцуулга, семинар зэрэгт оролцон мэдээлэл олж авах боломжтой.

## ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-ЫН ДҮНГ ШАЛГУУР БОЛГОН ЯПОНД ОЧИХООС ӨМНӨ АВАХ ЭЛСЭЛТИЙН ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД ШААРДАГДАХ ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-ЫН ОНОО

Хэдээс дээш оноо авбал тэнцэх талаар дараах сайтаас харна уу.

(Зөвхөн албан ёсоор нийтлэх зөвшөөрөлтэй сургуулийн мэдээлэл л байгааг анхаарна уу.)

<http://www.jasso.go.jp/eju/meyasu.html>



## ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТЫН ДҮНГ ШАЛГУУР БОЛГОН ЯПОНД ОЧИХООС ӨМНӨ АВАХ ЭЛСЭЛТИЙН ЗӨВШӨӨРӨЛ АВЧ ЯПОНД СУРАЛЦСАН ГАДААД ОЮУТНУУДЫН СЭТГЭГДЭЛ

- Өөрийнхөө эх орондоо японд суралцах бэлтгэлээ хийсэн болохоор зөвхөн шалгалтандаа анхаарлаа хандуулж, сайн бэлдэж чадсан. (Солонгос)
- Шалгалт өгөхийн тулд япон явах шаардлагагүй байсан нь юу юунаас илүү мөнгө, санхүүгийн хувьд хэмнэлттэй байсан. (Тайван)
- Япон явалгүйгээр өөрийнхөө улсад бүх хүч чадлаа дайчлан хичээлээ давтаж, улмаар шалгалтандаа тэнцсэн минь зөвхөн миний хувьд төдийгүй тусалж дэмжиж байсан хүмүүсийн хувьд ч үнэхээр баярлаж, бахархмаар үйл явдал болсон гэж боддог. (Индонез)
- Японд суралцах шалгалтын дүнг шалгуур болгон Японд очихоос өмнө авах элсэлтийн зөвшөөрөлийг авч чадвал мөнгө, санхүүгийн ачаалал багасаад зогсохгүй японд сурахыг хүсдэг олон залуучуудын мөрөөдөл биелэх байх гэж бодож байна. (Монгол)

Японд суралцах шалгалт (EJU) өгөн японд суралцсан оюутнуудын сэтгэгдлийг дараах веб сайтаас харна уу.

<http://www.jasso.go.jp/eju/voice.html>





## **ТЭТГЭЛЭГ (БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ГАДААД ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГИЙН ХҮСЭЛТ ГАРГАХ ТОГТОЛЦОО)**

“Боловсрол Шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэг” гэдэг нь Японы оюутныг дэмжих байгууллагаас Японы их, дээд сургууль, түргэвчилсэн хугацааны дээд сургууль, техникийн коллеж (3-р курсээс дээш), мэргэжлийн сургууль зэрэгт үндсэн оюутнаар суралцах оюутанд олгодог тэтгэлэг юм.

Японд суралцах шалгалт (EJU)-д өндөр оноо авсан шалгалт өгөгч нарт зориулсан “Боловсрол Шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэг”-ийн хүсэлт гаргагч гэж батламжлах тогтолцоо байдаг.

Хүсэлт гаргагчаар батламжлагдсан хүн тэтгэлэг хүлээн авахын тулд элсэн орсон сургуулиараа дамжуулан шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлнэ.

Боловсрол Шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэгийн хүсэлт гаргах тогтолцооны талаар дараах веб сайтаас үзнэ үү.

<http://www.jasso.go.jp/scholarship/yoyakuseido.html>

### **Тэтгэлэгийн хэмжээ (Бакалавр)**

сард 48000 иен (2015 оны байдлаар)

### **Тэтгэлэг олгох хугацаа:**

Элсэлтийн хугацаанаас хамаарч өөр өөр байдаг тул “Боловсрол Шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэгийн хүсэлт гаргах тогтолцоо”-ны веб сайтаас харна уу.

Японд суралцах шалгалт (EJU)-ын хичээл тус бүрээс өндөр оноо авч тэтгэлэг авахаар батламжлагдсан гадаадад шалгалт өгсөн шалгалт өгөгчийн хувьд шаардлагатай нөхцлийг биелүүлсэн тохиолдолд анх элссэн сургуулиа төгстөл тэтгэлэг үргэлжлүүлэн авах боломжтой.

### **Хүсэлт гаргах арга:**

Японд суралцах шалгалт (EJU) өгөхөөр өргөдөл гаргах үедээ өргөдлийн маягт дээрх тэтгэлэг хүсэх гэсэн дөрвөлжин дотор дугуй ○ гэсэн тэмдэг тавих хэрэгтэй.

## **Сонгон шалгаруулах арга:**

Японд суралцах шалгалт (EJU)-д өндөр оноо авсан хүмүүсээс сонгон шалгаруулдаг.

## **Хариуг мэдэгдэх:**

Тэтгэлэгийн болзол хангасан шалгалт өгөгчид “Боловсрол Шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэгийн хүсэлтийг баталгаажуулах тодорхойлолт”-ыг шуудангаар илгээнэ. Мөн “Боловсрол Шинжлэх ухааны яамны гадаад оюутны сургалтын тэтгэлэгийн хүсэлт гаргах тогтолцоо”-ны веб сайтад тэтгэлэг авахаар батламжлагдсан хүмүүсийн японд суралцах шалгалт (EJU)-ын бүртгэлийн дугаарыг байршуулна.

## **ЯПОНД СУРАЛЦАХ ШАЛГАЛТ (EJU)-Г МОНГОЛ УЛСАД МОНГОЛЫН ЯПОН ХЭЛНИЙ БАГШ НАРЫН ХОЛБОО ХАРИУЦАН ЗОХИОН БАЙГУУЛДАГ**

Монголын Япон хэлний Багш нарын Холбоо нь 1998 онд Монгол улсад япон хэлний сургалт хэрэгжүүлж буй бүхий л шатны сургуулийн япон хэлний багш нарыг эгнээндээ нэгтгэн байгуулагдсан мэргэжлийн, сайн дурын төрийн бус байгууллага юм. Тус Холбоо нь байгуулагдсан цагаасаа япон хэлний сургалт судалгаа, сурах, сургах аргазүйг чанарын түвшинд хөгжүүлэх, сурах бичиг зохиох, багш нарын мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын гадаад хэлний сургалтын ололт дэвшлээс суралцах, өөрсдийн ололт амжилтаа мэдээлэх солилцох зэрэг хүрээнд бүхий үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ. Япон хэлийг сонирхон судлах суралцагчийн тоо нэмэгдэхийн хирээр япон хэлний сургалтын байгууллагууд олноор байгуулагдсан 2000 оноос эхлэн “Япон хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт”, 2002 оноос Японы Оюутан дэмжих Байгууллага (JASSO)-ын “Хувийн зардлаар япон улсад суралцах шалгалт”-ыг өөрийн оронд зохион байгуулж байна. Эдгээр шалгалтыг зохион байгуулах болсноор япон хэлийг суралцагчдын мэдлэгийн өөрийн үнэлгээ төдийгүй сургалтын байгууллагын сургалтын чанар, үр дүнгээ үнэлэх нэгээхэн боломжийг бүрдүүлж өгсөн юм. Түүнчлэн

хүүхэд залуучуудын япон хэл сурах сонирхлыг нэмэгдүүлэх, япон орны талаар улам илүү ойлгох, хэлний мэдлэг чадварыг нь хөгжүүлэх зэрэг зорилгоор, тухайлбал, 1995 оноос Монгол дахь Япон улсын Элчин Сайдын Яамтай хамтран “Японоор хэн сайн ярих вэ” уран илтгэлийн уралдааныг тасралтгүй өнөөг хүртэл зохион байгуулж ирлээ.

2007 оноос Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн япон хэлний багш нарыг хамруулсан “Япон хэлний боловсрол” сургалт судалгааны олон улсын симпозиумыг тогтмол явуулж байна. Гадаад дотоодын япон хэлний багш, судлаач нарыг урьж, илтгэл тавиулах, хамтарсан сургалт хийх зэргээр багш нарыг олон улсын япон хэл, заах аргын судалгааны орчин үеийн чиг хандлагатай танилцах, харилцан суралцах, мэргэжлийн ур чадвар, онолын мэдлэгээ дээшлүүлэх зорилготой. Мөн сургалт, судалгааны ажлыг тогтворжуулах зорилгоор 2007 оноос Монголын япон хэлний багш нарын холбооны дэргэд “Япон хэлний сургалт судалгааны баг” байгуулан сар тутам, бүх шатанд япон хэл зааж буй багш нар өөрсдийн сургалт, судалгаатай холбоотой асуудлаар хэлэлцэн санал солилцдог болсон.

Эдгээр ажлын үр дүнг нэгтгэн нийтийн хүртээл болгох улмаар тухайн жилийн ажлын тайлан болгон “Нихонго но хироба” эмхэтгэлийг хэвлэн гаргаж байгаад 2014 оноос бусад олон гадаад хэлний мэргэжлийн хүмүүстэй уялдаа холбоогоо хөгжүүлэх, мэдээлэл солилцох үүднээс “Япон хэлний боловсрол” мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүл хэвлүүлэн нийтийн хүртээл болгож байна. 2000-2004 оны хооронд монголын ерөнхий боловсролын суралцагчдад зориулсан “Би чадна” япон хэлний сурах бичгийг тус холбооноос эрхлэн гаргасан бөгөөд олон улсын гадаад хэлний сургалтын өөрчлөлт шинэчлэлтэй уялдан 2010 оноос Япон улсын Япон сангийн дэмжлэгээр япон хэлний сургалтын олон улсын стандартын баримт бичгийг монгол хэлнээ хөрвүүлэн, монгол хөрсөнд нутагшуулах, сурах бичиг зохиох төслийг хэрэгжүүлж эхэлсэн. 2015 онд энэхүү төслийн судалгааны үр дүн Монгол суралцагчдад зориулсан япон хэлний стандартад тулгуурласан “Дэкирүмон” цуврал 7 дэвтэр сурах бичгийг бага, дунд, дээд сургуулийн япон хэлний багш нарын баг, Япон сангийн мэргэжилтний оролцоотой амжилттай хэвлүүлэн гаргалаа. Өдгөө Монголын Япон хэлний Багш нарын Холбоо нь 20 гаруй их дээд сургууль, 30-аад бага дунд сургууль, 20 орчим сургалтын төв, дамжааны 70 гаруй багш нарыг эгнээндээ нэгтгэн, үйл ажиллагаагаа явуулж байна.

Хаяг: Улаанбаатар 46 А, Шуудангийн хайрцаг 406

Е-мэйл: burd202000@yahoo.co.jp

Facebook хаяг: EJU-Mongolia

# www.jasso.go.jp/eju/

EJU

**Японд суралцах шалгалт (EJU)-ын асуултууд**  
[www.jasso.go.jp/eju/examination.html](http://www.jasso.go.jp/eju/examination.html)

**Японд суралцах шалгалт (EJU)-ын дүнг  
шалгуур болгон Японд очихоос өмнө авах  
элсэлтийн зөвшөөрлийг олгодог  
сургуулиудын мэдээлэл**  
[www.jasso.go.jp/eju/baij.html](http://www.jasso.go.jp/eju/baij.html)

**Хэвлэлтэнд:** 2015 оны 8-р сард  
(Худалдан борлуулахыг хориглоно)

**Бие даасан хуулийн этгээд  
Японы Оюутныг Дэмжих Байгууллага  
Гадаад оюутан хариуцсан хэлтэс  
Японд суралцах шалгалт хариуцсан тасаг**  
Хаяг: 〒153-8503 Токио хот Мэгуро дүүрэг  
Комаба 4-5-29  
Утас: +81-3-6407-7457  
Факс: +81-3-6407-7462  
E-mail: [eju@jasso.go.jp](mailto:eju@jasso.go.jp)